



АЛГОРИТМЫН ДАВАМГАЙЛАЛ БА МЭДЭЭЛЛИЙН ОРЧНЫ ӨӨРЧЛӨЛТ

Б.Түвшинтөр*,
Б.Наранбаатар**

**МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны
тэнхимийн багш, магистр(MSc.)*

***МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны
тэнхимийн эрхлэгч, дэд профессор, доктор (Ph.D.)*

Түлхүүр үгс: Алгоритмын давамгайлал, алгоритм ба олон нийтийн санал бодол, алгоритмын хаалгач, дижитал платформууд, нийгмийн сүлжээний алгоритмууд, олон нийтийн санал бодлыг бүрдүүлэх, хувийн тохиргоо, шүүлтүүрийн бөмбөлөг, эхо камер, хуурамч мэдээлэл, медиа хуульд нийцэх зарчим, нийтийн итгэл, платформчлол, дижитал сэтгүүл зүй

Дижитал платформууд болон алгоритмын системүүдийн хурдацтай өргөжин хөгжиж буй нь орчин үеийн нийгэмд олон нийтийн санаа бодол бүрэлдэн тогтох, түгэх үйл явцыг үндсээр нь өөрчилж байна. Сошиал медиа платформууд, хайлтын системүүд, мэдээ санал болгох алгоритмуудад шингэсэн эдгээр систем нь мэдээллийн ил тод байдал, эрэмбэлэлт болон түгээлтийг тодорхойлох механизм болон хувирч, олон нийтийн мэдээллийн орон зайд голлох нөлөө үзүүлж байна.

Энэхүү судалгаа нь алгоритмын систем ба олон нийтийн санаа бодлын төлөвшлийн хоорондын хамаарлыг шинжилсэн өмнөх судалгаануудын мета-анализ бөгөөд томоохон эрдэм шинжилгээ, судалгааны сангуудаас системтэйгээр сонгосон бүтээлийн үр дүнг нэгтгэн дүгнэсэн болно. Алгоритмын хувиарлалт, хувийн тохиргоонд суурилсан шүүлтүүр,

оролцоонд тулгуурласан эрэмбэлэлтийн механизм нь хэрэглэгчдийн мэдээлэлд хүрэх орчин, нийтлэг санаа бодлын бүрэлдэх үйл явцад хэрхэн нөлөөлдөг талаархи эмпирик судалгаануудыг нэгтгэн харуулсан болно.

Судалгааны дүнгээс харахад санал болгох систем болон контент эрэмбэлэгч алгоритмууд нь ихэвчлэн олон нийтийн анхаарал татсан, сэтгэл хөдлөл өдөөсөн эсвэл өндөр хамааралтай контентыг дэмжих хандлагатай бөгөөд энэ нь хэрэглэгчдийн мэдээллийн орчныг тодорхой хэмжээнд чиглүүлж, үзэл бодлын нэгтэлыг хэт хүчтэй болгох магадлалыг нэмэгдүүлдэг. Гэсэн хэдий ч судалгаанууд алгоритмын нөлөө нь дангаар шийдвэрлэгч хүчин зүйл биш бөгөөд хэрэглэгчийн хувийн сонголт, мэдээлэл хэрэглэх хэв маяг, нийгэм-улс төрийн өргөн хүрээний хүчин зүйлстэй харилцан үйлчилдэг болохыг харуулжээ. Мөн зарим судалгаанд алгоритмын санал болгох мөчлөг болон оролцоонд суурилсан эрэмбэлэлтийн системүүд нь туйлшрал, ташаа мэдээлэл, сенсац шуугиант контентыг улам хүчтэй түгээх нөхцөл болдгийг тэмдэглэсэн байна.

Удиртгал. Сүүлийн арван жилд дижитал платформууд нь мэдээлэл үйлдвэрлэх, түгээх, хэрэглэх үндсэн орчин болж, олон нийтийн санал бодол бүрэлдэх үйл явцыг мэдэгдэхүйц өөрчилсөн. Интернет хэрэглэгчдийн тоо тогтмол өсөхийн хэрээр хүмүүс мэдээ, мэдээллийг улам бүр онлайн эх сурвалжаас авч байгаа бөгөөд нийгмийн сүлжээний платформууд мэдээллийн экосистемийн төв зангилаа болон хөгжиж байна. Энэхүү шилжилт нь олон нийтийн харилцааны бүтэц, динамикийг сууриар нь өөрчилж, мэдээ үйлдвэрлэгч, түгээгч болон хүлээн авагчдын хоорондын уламжлалт зааг ялгааг бүдгэрүүлсэн байна (Leblanc & Roux, 2025).

Ийнхүү өөрчлөгдөж буй мэдээллийн орчинд алгоритмууд нь мэдээллийг зохион байгуулах, шүүх, эрэмбэлэх үндсэн үүрэг бүхий дэд бүтцийн гол элемент болон тодорчээ. Алгоритмын системүүд нь төвийг сахисан зуучлагч бус, харин контентын визуаль шинж, хүртээмжийг тодорхойлж (Hunt & McKelvey, 2019; Møller, 2022), ямар асуудал онцгой байр суурь эзлэх, олон нийтийн хэлэлцүүлэгт хэрхэн тайлбарлагдахыг чиглүүлэх болжээ. Үүний үр дүнд алгоритмууд нь сэтгүүлчид болон хэвлэл мэдээллийн байгууллагуудын уламжлалт редакцийн үүргийг хэсэгчлэн орлох, эсхүл дахин зохион байгуулах нөлөө үзүүлэх болсон.

Эдгээр өөрчлөлт нь “алгоритмын олон нийтийн санал бодол” хэмээх ойлголт бий болоход хүргэсэн бөгөөд уг ойлголт нь алгоритмын зуучлал давамгайлсан орчинд олон нийтийн санал бодол хэрхэн бүрэлдэн тогтож буй үйл явцыг илэрхийлдэг (Reviglio, 2020; Chalikiropoulou нар, 2025). Энэ хүрээнд алгоритмууд нь зөвхөн мэдээллийн тархалтыг зохицуулахаас гадна асуудлын онцлогийг тодорхойлох, эх сурвалжийг сонгох, тодорхой өгүүлэмжийг “онцгойроход” чухал үүрэг гүйцэтгэж байна. Иймээс олон

нийтийн санал бодол нь зөвхөн хүний ухамсартай харилцааны үр дүн бус, харин хэрэглэгчид, платформууд болон алгоритмын дэд бүтцийн хоорондын нарийн төвөгтэй харилцан үйлчлэлээс үүсэлтэй юм.

Алгоритмын систем нь мэдээлэлд хандах боломж, оролцоог өргөжүүлэх боломжтой ч ил тод байдал, хариуцлага, алгоритмын зохицуулалттай холбоотой шинэ сорилтуудыг дагуулж байна. PRISMA-д суурилсан арга зүйн стандартыг баримталсан уг судалгаа нь чанарын, тоон болон холимог арга зүйн олон төрлийн судалгааны үр дүнг нэгтгэж, алгоритмын дэд бүтэц нь мэдээллийн урсгал, сэтгүүл зүйн практик, үзэгчдийн ойлголтод хэрхэн нөлөөлж буйг тодруулсан юм (Ahmmad et al., 2025; Areeb нар, 2023).

Судалгааны үр дүнгээс үзэхэд алгоритмууд нь мэдээлэл дамжуулах төвийг сахисан зуучлагч бус, харин нийгэм-технологийн идэвхтэй агент хэлбэрээр үйлчилж, цахим орчин дахь мэдээллийн харагдах байдал, байршлын эрэмбэ болон хуульд нийцэх чанарыг идэвхтэй зохион байгуулж байна (Leblanc & Roux, 2025; Эссиен, 2025).

Юуны өмнө, өгөгдөлд суурилсан хэмжүүр, платформын дотоод логик нь редакцийн шийдвэр гаргах процесст нэвтэрснээр алгоритмын gatekeeping үйл явц нь редакцийн хөдөлмөрийн хуваарьт нөлөөлж байна. (Møller, 2022; Хант ба МакКелви, 2019). Үүний үр дүнд мэдээний үнэ цэнэ нь олон нийтэд ач холбогдолтой гэхээс илүүтэйгээр “хүртээмжтэй байдал”, хэрэглэгчийн оролцоог оновчтой болгох чиглэлд шилжиж буй хандлага ажиглагдлаа.

Хоёрдугаарт, хувийн тохиргоо болон мэдэгдлийн системүүд нь контентыг шүүн ангилж, тодорхой мэдээллийг тэргүүлэх байрлалд оруулах замаар олон нийтийн санал бодлыг бүрдүүлэхэд хүчтэй нөлөөлж байна. Энэ нь тодорхой мэдээлэл бусдаас онцгойрон ялгарах, эхо камерын үзэгдэл (хүмүүс өөрсдийн үзэл бодол, итгэл үнэмшилтэй ижил төстэй мэдээлэл, санал бодлыг л дахин дахин хүлээн авч, бат бөх болгодог нөхцөл -зох.) болон үзэл бодлын туйлшрал улам бэхжин гүнзгийрч буй нь тогтоогдсон (Bauer et al., 2024; Areeb нар, 2023).

Гуравдугаарт, алгоритмын зуучлал нь медиа хуульд нийцэх зарчмын ойлголтыг дахин тодорхойлж, мэдээлэлд итгэх итгэл уламжлалт сэтгүүл зүйн мэргэжлийн стандартаас илүүтэйгээр визуаль шинж, хамаарлын үзүүлэлтүүдтэй улам бүр уялдах болж байна (Tayie, 2025; Foà & Couraceiro, 2024). Ингэснээр редакцийн уламжлалт үнэт зүйлс бус платформд дасан зохицсон байдлыг чухалчлах хандлага ажиглагдаж байна.

Дөрөвдүгээрт, алгоритмын өсгөх (amplification) механизм нь хэрэглэгчдийн идэвх болон автомат мэдэгдлийн давтамжаар дамжин хуурамч мэдээлэл, нийгмийн талцал, хэрэглэгчийн өөрийн цензурийг эрчимжүүлж байна (Essien, 2025; Огвони нар, 2025).

Ерөнхийд нь дүгнэхэд, уг судалгаа нь алгоритмын системүүд олон нийтийн санаа бодлыг бүрдүүлэх үйл явцыг үндсээр нь өөрчилж, мэдээллийн үйлдвэрлэл ба хэрэглээний логикийг шинээр зохион байгуулж буйг харуулж байна. Эдгээр динамик өөрчлөлтүүд нь мэдээллийн иж бүрэн байдал, ардчилсан харилцааг хамгаалахын тулд алгоритмын системүүдийн ил тод байдал, хариуцлага, зохицуулалт болон удирдлагыг бэхжүүлэх зайлшгүй шаардлагатайг онцолж байгаа ажээ.

Судалгааны бүтээлийн тойм, арга зүй

Энэхүү судалгаа нь системтэй судалгааны бүтээлийн түүвэрт суурилсан чанарын мета-синтезийн аргыг ашиглан алгоритмын давамгайлал олон нийтийн үзэл бодолд хэрхэн нөлөөлж байгааг шинжилсэн. Судалгааны арга зүйн дизайн нь харилцаа холбоо, медиа судалгааны олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартуудыг баримталж, судалгааны бүх үе шатанд ил тод байдал, арга зүйн шаардлага, практик ач холбогдлыг хангахыг зорьсон болно.

1. Судалгааны дизайн

Судалгаа нь онолд суурилсан системтэй түүврийн загварыг ашиглан, туршилтын судалгааны үр дүнг сэдэвчилсэн чанарын синтезээр нэгтгэх арга зүйг ашигласан. Судалгааны бүтээлүүд нь чанарын, тоон болон холимог аргуудыг хамарсан тул давтагдан илэрч буй хэв маяг, механизм, харилцан хамаарлыг илрүүлэхэд чанарын мета-синтез тохиромжтой гэж үзлээ.

Сэдвийн хүрээнд задлан шинжлэхийн тулд дараах гурван гол онолын шаардлагад үндэслэсэн болно.

- Алгоритмын гэйткипинг /мэдээллийн хаалгач/ онол
- Актор-Сүлжээний онол (Actor-Network Theory, ANT)
- Технологийн нийгмийн хэлбэржүүлэлтийн онол (Social Shaping of Technology, SST)

Эдгээр онолын хүрээ нь эмпирик нотолгоог кодчлох, тайлбарлах, синтезлэх үйл явцыг чиглүүлж, олон төрлийн судалгааны орчин, арга зүйн ялгаатай байдлын дунд ойлголтын уялдаа холбоог хадгалахад чиглэсэн (Ahmmad et al., 2025; Areeb et al., 2023).

2. Хайлтын стратеги

Судалгаанд хоёр үндсэн академик мэдээллийн санг ашиглан системтэй хайлт хийсэн. Үүнд:

- Web of Science (Core Collection)
- Scopus

Эдгээр эрдэм шинжилгээний мэдээллийн сангууд нь харилцаа холбоо,

сэтгүүл зүй, медиа судлалын олон улсын хянагдсан сэтгүүлүүдийг өргөн хүрээтэй хамардаг тул сонгогдсон. Хайлтын үйл явц 2025 оны 9 дүгээр сарын 3-нд дуусч, нийт 1,084 өгүүлэл илэрсэн.

Хайлтын асуулгыг Boolean операторууд, хяналттай үгийн сан (controlled vocabulary), өгөдсөн түлхүүр үгсийг хослуулан боловсруулсан. Энэхүү хайлтын стратеги нь судалгааны хамрах хүрээ болон хоорондын хамаарлыг тэнцвэртэй байлгах боломжийг бүрдүүлсэн.

3. Ашиглах, эс ашиглах шалгуур

Арга зүйн чанарыг баталгаажуулахын тулд эх сурвалжийг ашиглах, эс ашиглах тодорхой шалгуур-ыг хэрэгжүүлсэн.

Ашиглах шалгуур:

- Хянан шалгасан өндөр түвшний судалгаанууд (чанарын, тоон болон холимог арга):
- 2015–2025 оны хооронд хэвлэгдсэн бүтээлүүд:
- Сэтгүүл зүй, медиа систем болон олон нийтийн санаа бодол бүрэлдэх үйл явц дахь алгоритмын нөлөөнд төвлөрсөн судалгаанууд:

Эс ашиглах шалгуур:

Эмперик бус бүтээлүүд (онолын эсээ, редакцийн тайлбар, сэтгүүлчийн өгүүлэл):

- Харилцаа холбоо, медиа судлалын хүрээнээс гадуур чиглэсэн судалгаа:
- Өгөгдлийн сангийн индексжүүлэлт болон хугацааны шаардлагыг хангаагүй эх сурвалжууд:

Эдгээр шалгууруудыг хэрэгжүүлснээр эцсийн өгөгдлийн сан нь арга зүйн хувьд найдвартай, эмпирик нотолгоонд суурилсан судалгаануудаас бүрдэх нөхцөлийг бүрдүүлэв.

4. Шалгаруулалт ба судалгааны сонголт

Судалгааны сонгон шалгаруулах үйл явц нь PRISMA (Preferred Reporting Items for Systematic Reviews and Meta-Analyses) хүрээний дагуу явагдсан бөгөөд ил тод байдал, практик ач холбогдол, арга зүйн нарийвчилсан үнэлгээний шаардлагыг бүрэн хангасан.

4.1. Тодорхойлох үе шат (Identification)

Төлөвлөсөн өгөгдлийн сангийн хайлтаар нийт 1,084 судалгааны бичиг баримт илрүүлсэн. Эдгээр судалгааны баримтыг дараах олон улсын судалгаа, эрдэм шинжилгээний мэдээллийн сангуудаас авсан болно. Үүнд:

Web of Science (n = 893)

Scopus (n = 191)

Энэ үе шатанд алгоритмын давамгайлал болон олон нийтийн санал бодолтой холбоотой бүх боломжит судалгааг хамруулах зорилгоор хэл, он, судалгааны загвараар хязгаарлаагүй, өргөн хүрээний хайлт хийж, холбогдох судалгаануудыг бүрэн хамруулахыг зорив.

4.2. Нягтлах үе шат (Screening)

Тодорхойлох үе шатны дараа судалгааны бүтээлүүдийн давхардлыг шалгасан бөгөөд агуулгын болон баримтын давхцал илрээгүй. Иймд энэ шатанд 1,084 бүтээл бүгд хүчинтэй хэвээр үлдсэн.

Дараагийн шатанд бүх судалгааны өгүүллийн гарчиг болон товч агуулгыг бидний судалгааны зорилго, хамрах хүрээтэй нийцэж буй эсэхийг үнэлэв.

Шалгасан бичлэгүүд (n = 1,084)

Хасагдсан бичлэгүүд (n = 900)

Энэ шатанд дараах үндэслэлээр судалгаанууд хасагдав. Үүнд:

Алгоритмын нөлөө эсвэл олон нийтийн санал бодолтой шууд хамааралгүй байсан:

Эрдэм шинжилгээний бус эсвэл хянан магадлаагүй эх сурвалж:

Бидний судалгааны хүрээтэй онол, үзэл баримтлалын зөрчилтэй:

4.3. Үнэлгээний үе шат (Eligibility)

Даараагийн шатанд үлдсэн 184 эрдэм шинжилгээний өгүүллийн эх бичвэртэй танилцан хянаж, судалгаанд оруулах эсэхийг илүү нарийвчилсан шалгуураар үнэлэв.

Бүрэн текстээр үнэлсэн өгүүллүүд (n = 184)

Энэ шатанд дараах шалтгаануудын улмаас 106 өгүүллийг хасав. Үүнд:

- Онол, практикийн ач холбогдол хангалтгүй
- Арга зүйн найдвартай байдал сул
- Өгөгдөл бүрэн бус эсвэл эх бичвэрийг бүрэн харах боломжгүй
- Судалгааны үр дүнгийн давхцал, илүүдэл

4.4. Хамруулсан судалгааны бүтээлүүд (Included Studies)

Үнэлгээний дараа эцсийн байдлаар 78 судалгааны ажил чанарын синтезд багтсан болно. Эдгээр судалгаанууд нь алгоритмын давамгайлал олон нийтийн санал бодолд хэрхэн нөлөөлдөг механизм, гол нөлөөллийн хэлбэрүүдийг тодорхойлох мета-анализын үндсэн суурь болсон (Зураг 1).

Зураг 1. PRISMA судалгааны сонголтын үйл явцын зураглал



78 эмпирик судалгаанд тулгуурласан мета-анализын үр дүнгээс харахад алгоритмын давамгайлал нь олон нийтийн санал бодол бүрэлдэх үйл явцад системтэй бөгөөд олон талт нөлөө үзүүлдэг нь тодорхой байна. Шүүн, задлан шинжилсэн бүтээлүүдээс гарсан хамгийн гол өнцгүүдийн нэг нь алгоритмын системүүд нь редакцийн өдөр тутмын ажлын явцад зүгээр нэг нөлөөлөөд зогсохгүй, түүнийг сууриар нь шинэчилж байгаад оршино.

Энэхүү өөрчлөлт дараах үндсэн шинжээр илэрнэ. Үүнд:

- Хандалтад суурилсан редакцийн үйл ажиллагаа илт давамгайлах;
- Сэтгүүлчийн ур чадвар, алгоритмын аль нь илүү хэрэглэгчид хүрэх вэ гэх өрсөлдөөн;
- Мэдээллийн уламжлалт үнэ цэнэ, ач холбогдлоос илүү хэрэглэгчид хүртээжтэй, хялбар байх хандлага рүү шилжсэн.

Үүнээс гадна алгоритмын системүүд нь мэдээ, мэдээллийг олох, боловсруулах, түгээх процесст шуурхай байдлын нээлт шаардлагыг бий болгосон. Хэрэглэгч өөрийн сонирхож буй, эрх ашигт нийцсэн мэдээ, мэдээллийг real-time буюу яг одоо мэдэхийг хүсдэг болсноор редакцийн

ажлыг хурдасгаж, баримт нягтлах, задлан шинжлэхээс илүү “бусдаас түрүүнд” гэх хандлагыг бэхжүүлснээр сэтгүүл зүйн уламжлалт стандартад өөрчлөлт авчирч байна.

Хэлэлцүүлэг. Энэхүү мета-анализын үр дүнд алгоритмын давамгайлал нь олон нийтийн санаа бодол бүрэлдэх үйл явцад нэгэнтээ бүтцийн чанартай өөрчлөлт болсон гэдгийг системтэйгээр нотолж байна. Алгоритмууд нь мэдээллийн урсгалыг зүгээр дамжуулдаг төвийг сахисан зуучлагч бус, харин мэдээллийн орчныг идэвхтэй зохион байгуулж, сэтгүүл зүйн практикийг өөрчлөн төлөвшүүлж, олон нийтийн хэлэлцүүлгийн нөхцөлийг тодорхойлдог нийгэм–технологийн хүчин зүйлс юм.

1. Судалгааны хамгийн чухал дүгнэлтүүдийн нэг нь алгоритмууд нь мэдээллийн дамжуулан зуучлагчийн үүргээс хальж мэдээлэл харилцааны бүтцийг тодорхойлогч болж явдал юм. Уламжлалт харилцааны загварууд медиаг мэдээлэл үйлдвэрлэгчид ба үзэгчдийн хоорондох дамжуулагч болгон ойлгож ирсэн. Харин энэхүү синтезийн нотолгоо нь алгоритмын системүүд мэдээлэл ямар хэлбэрээр харагдах, хэнд хүрэх, хэрхэн тайлбарлагдах нөхцөлийг урьдчилан бүтэцчилдэг болохыг харуулж байна.

“Алгоритмын олон нийтийн санал бодол” хэмээх ойлголт нь олон нийтийн үзэл бодол нь хэрэглэгчид, платформууд, автоматжуулсан системүүдийн харилцан үйлчлэлээс үүссэн алгоритмаар сонгогдсон орчинд хэлбэрждэгийг онцолдог. Энэ хүрээнд алгоритмууд нь ямар асуудал чухалчилж тавигдах, тэдгээрийг хэрхэн нэрлэж тодорхойлох, ямар тайлбар, өгүүлэмж давамгайлахыг шийдвэрлэж, ингэснээр зорилго тогтоох болон утга бүтээх үйл явцад гүнзгий нөлөөлдөг.

2. Судалгааны үр дүнгээс харахад өгөгдөлд суурилсан байх, ашиглаж буй платформдоо нийцэж дасан зохицох нь сэтгүүл зүйн практикт үйл ажиллагааны гол логик хөшүүрэг болж эхэлсэн. Интернет хандалтын хэмжүүр, дүн шинжилгээг түлхүү ашиглах болсноор редакциуд мэдээ, сэдэв, үйл явдлыг сонгох, боловсруулахуламжлалт арга, шалуур ч хувьсаж байна.

Энэ өөрчлөлтийн нөлөөгөөр дараах хэд хэдэн үр дагавар бий болов:

- Баримт нягтлах процесс суларсан: - Хэрэглэгчид мэдээллийг бодит цаг хугацаанд маш товчоор хурдан авах шаардлага тавьдаг болсноор сэтгүүлч, редакциуд цаг хугацаанд “шахагдаж”, яаравчилсан огрмоор ажиллаж буй тул баримт нягтлах, мэдээллийг баяжуулан дэлгэрүүлэх боломж хомс болсон байна.

- Мэдээ, мэдээллийн үнэлэмжийн хэмжүүр өөрчлөгдсөн: - Мэдээ үнэн бодитой, олон нийтийн эрх ашигт нийцсэн, ашигтай байх ёстой гэсэн уламжлалт шалгуураас илүү хэдэн лайк, шейр цуглуулсан нь

чухал үзүүлэлт болж хувирсан.

- Бэлгэдэл төдий хараат бус байдал – Сэтгүүлчид юу бичих, яаж бичих сонголт, эрх чөлөө нь оршсон хэвээр мэт боловч алгоритмын үндсэн зарчим, хэрэглэж буй платформын шалгуураар хязгаарлагдаж байна.

Эдгээр өөрчлөлтүүд нь найдвартай, тэнцвэртэй мэдээлэл “нийлүүлэгч” сэтгүүл зүйн уламжлалт хэм хэмжээнд алгоритмын давамгайлал илэрч буйг нотолно.

3. Алгоритм нь хувь хэрэглэгчийн сонголтод үйлчилдэг. Хүн юу үзэж, уншиж байна, юунд итгэж, үйл ядвлыг аль өнцгөөс харж, ойлгож байна, түүнийгээ дэмжсэн мэдээ, мэдээллийг илүү сонирхож хүлээн авдаг. Түүнийг нь алгоритм улам дэмжиж, алсдаа тэр хэрэглэгчийн хувьд бусад байр суурь, өнцөг, үзэл бодлыг “олж харах” мэдээллийн орон зайг хааж байна. Энэхүү мета-анализийн хүрээнд хувь хүнд “үйлчлэх” эдгээр механизм нь үзэл бодлын туйлшралыг өдөөж, эхо-камерууд үүсгэж байгааг дахин нотолж байна. Энэ нь зөвхөн хувь хүний сонголтоор бус алгоритмын шүүлтүүрээр бий болж буй үзэгдэл юм.

Үүнээс гадна, энэхүү нөхцөлд хуурамч мэдээллийн уршиг, тархалт, түүнээс үүдэх эрсдэл улам ихэсч байгаа. Хэрэглэгчийн өмнөх хайлт, хандалт, сонирхсон мэдээлэлтэй “ойр” байгаа тохиолдолд хуурамч мэдээлэл нь санал болгох систем, мэдээлэл ангилан ялгах механизмын үр дүнд илүү тархан хэрэглэгчид “харагдах” боломж өсөж байна (Essien, 2025; Огвони нар, 2025).

4. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн олон нийтэд хүлээн зөвшөөрөгдөх, итгэл олох үйл явцад мөн өөрчлөлт гарч буйг манай судалгааны үр дүн харуулж байна. Алгоритм үйлчилж буй нөхцөлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлд итгэх олон нийтийн итгэл нь интернет орчинд платформуудын өгөгдөлөөр тодорхойлогддог болж байна.

Вэб-сайт, социал платформуудын хандалтын хэмжүүр, тоолуур, нөлөөлөгчдийн реакц зэрэг нь хүлээн авагчид мэдээ, мэдээллийг хэрхэн хүлээн авсан болохыг тооцох үнэлэмжийн шинэ шалгуур болсон (Tayie, 2025; Foà и Courageiro, 2024). Гэвч энэ тоон мэдээлэл нь тийм ч тогтвортой биш бөгөөд буруу ойлгогдох, манипуляцийн хэрэгсэл болох эрсдэлтэй.

Үүний зэрэгцээ алгоритмын ил тод бус байдал нь аливаа мэдээлэл яагаад “сонгогдон” тренд болж буй, эсвэл хязгаарлагдаж буй тал дээр тодорхойгүй байгаагаас харагдах ба алгоритмын “хар жагсаалтын” ажиллах зарчим нь хэрэглэгчдэд ойлгомжгүй хэвээр байна.

5. Орчин цагт цөөн тооны платформууд мэдээллийн орон зайд давамгайлж буй нь мөн мэдээллийн эрх мэдлийн төвлөрлийг бий болгож байна. Эдгээр

цөөн платформын түлхүүр бүтцийн үүрэг гүйцэтгэж буй алгоритмууд нь мэдээллийн хүртээмжийг хуваарилж, олон нийтийн хэлэлцүүлцгийн “уур амьсгалыг” удирдан залж байна гэсэн үг. Иймд дараах эрсдэлүүд үүснэ:

- Манипуляцийн эрсдэл: Туйлширсан эсвэл аливаа хуурамч мэдээллийг ашиглан тодорхой өнцөг байр суурийг олон нийтэд “тулгах” боломж алгортимаар дамжин бүрдэж болно.

- Илүү хүртээмжтэй, ашигтай, олон нийтэд илүү “ил” байхын тулд аливаа хэвлэл мэдээллийн байгууллага нь платформуудын алгоритмд нийцэж ажиллах шаардлага тулгарч байна. Энэ нь редакцийн бие даасан байдлыг сулруулж, платформуудын хүчийг нэмэгдүүлж байна (Reviglio, 2020; Chalikiopoulou и др., 2025).

- Алгоритмын системүүд нь үндэстэн дамнасан, тодорхой бус шинжтэй байгаа учраас зарим улс орон, бүс нутгийн хувьд удирдлагын тогтолцооны түвшинд үл ойлголцол бий болж байна.

Эдгээр сорилт нь алгоритмын давамгайлал нь зөвхөн технологийн үзэгдэл бус улс төр, эдийн засгийн хүчин зүйл болсныг илтгэнэ.

6. Бидний шүүн задлан шинжилсэн эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлүүдэд нийтлэг дурдаж байсан нэгэн асуудал бол алгоритмын системийн сөрөг үр дагаврыг шийдэхийн тулд найдвартай удирдлагын бүтэц байх ёстойг онцолсон явдал юм. Энэ бүтэц нь дараах түлхүүр асуудлыг шийдвэрлэдэг байх ёстой:

- Алгоритмууд илүү ойлгомжтой, ил тод байх
- Бие даасан судалгаа, эрдэм шинжилгээний ажилд болон аудитийн үнэлгээнд нээлттэй байх
- Нийгэм, олон нийтийн эрх ашгийг илүү тооцсон олон ургальч хэмжүүрийг хөгжүүлэх
- Аливаа платформыг удирдан зохион байгуулах процесст олон талын оролцоог хангах

Эдгээр алхамууд бол манипуляци, хэт туйлшрал, хуурамч мэдээллийн эрсдлүүдээс хамгаалах зайлшгүй шаардлагаас урган гарч байна.

7. Эцэст нь бидний мета-анализын үр дүнд алгоритмын давамгайллын асуудлыг салбар дундын болон олон улсын цар хүрээнд гүнзгийрүүлэн судлах шаардлагатайг онцолж байна. Улс орон, бүс нутаг хоорондын харьцуулсан судалгаа, тоон болон чанарын аргыг хослуулсан, алгоритмын ажиллах онолын моделийг шинэчлэхэд чиглэсэн гэх мэт цаашдын судалгааны сэтгүүл нээлттэй үлдэж байна.

Алгоритмын давамгайлал нь орчин үеийн олон нийтийн мэдээлэл харилцааны дэг жаягт хувьсал авчирч, мэдээлэл хэрхэн бий болох, итгэл үнэмшил хэр бий болгох, олон нийтийн ухамсарт хэрхэн нөлөөлөхийг

тодорхойлох хэмжээнд хүрчээ. Алгоритм нь зөвхөн интернет технологийн шийдэл, хэрэгсэл төдийгүй энэ цаг үеийн мэдээллийн эко-систем дэх идэвхтэй, маргаантай оролцогч болжээ.

Дүгнэлт

Энэ ажлын хүрээнд бид алгоритмын давамгайлал ба олон нийтийн санаа бодлын хамаарлыг өндөр түвшний 78 судалгааны бүтээлд тулгуурлан мета-анализ хэлбэрээр шинжиллээ. Үр дүн нь алгоритмын системүүд орчин үеийн мэдээлэл харилцааны төв дэд бүтэц болж, мэдээлэл хэрхэн үүсэх, түгэх, тайлбарлагдах арга замыг дижитал орчинд үндсээр нь өөрчилж байгааг нотолж байна.

Хамрагдсан судалгаануудаас үзвэл алгоритмууд зөвхөн технологийн шийдэл, тоолуур байгаад зогсохгүй мэдээллийн ил тод байдал, цахим орчин дахь мэдээллийн эрэмбэ, хүлээн зөвшөөрөгдөх байдлыг идэвхтэйгээр “зохицуулж” байгааг харууллаа.

Алгоритмын систем нь контентыг шүүн ангилж, тодорхой мэдээллийг тэргүүлэх байрлалд оруулах замаар олон нийтийн санал бодлыг бүрдүүлэхэд хүчтэй нөлөөлж байна. Энэ нь тодорхой мэдээлэл бусдаас онцгойрон ялгарах, эхо камерын үзэгдэл (хүмүүс өөрсдийн үзэл бодол, итгэл үнэмшилтэй ижил төстэй мэдээлэл, санал бодлыг л дахин дахин хүлээн авч, бат бөх болгодог нөхцөл -зох.) болон үзэл бодлын туйлшрал улам бэхжин гүнзгийрч буй нь тогтоогдсон (Bauer et al., 2024; Areeb нар, 2023).

Алгоритм нь хувь хэрэглэгчийн сонголтод үйлчилдэг. Хүн юу үзэж, уншиж байна, юунд итгэж, үйл ядвлыг аль өнцгөөс харж, ойлгож байна, түүнийгээ дэмжсэн мэдээ, мэдээллийг илүү сонирхож хүлээн авдаг. Түүнийг нь алгоритм улам дэмжиж, алсдаа тэр хэрэглэгчийн хувьд бусад байр суурь, өнцөг, үзэл бодлыг “олж харах” мэдээллийн орон зайг хааж байна. Энэхүү мета-анализийн хүрээнд хувь хүнд “үйлчлэх” эдгээр механизм нь үзэл бодлын туйлшралыг өдөөж, эхо-камерууд үүсгэж байгааг дахин нотолж байна. Энэ нь зөвхөн хувь хүний сонголтоор бус алгоритмын шүүлтүүрээр бий болж буй үзэгдэл юм.

Үүнээс гадна, энэхүү нөхцөлд хуурамч мэдээллийн уршиг, тархалт, түүнээс үүдэх эрсдэл улам ихэсч байгаа. Хэрэглэгчийн өмнөх хайлт, хандалт, сонирхсон мэдээлэлтэй “ойр” байгаа тохиолдолд хуурамч мэдээлэл нь санал болгох систем, мэдээлэл ангилан ялгах механизмын үр дүнд илүү тархан хэрэглэгчид “харагдах” боломж өсөж байна (Essien, 2025; Огвони нар, 2025).

Ерөнхийд нь дүгнэхэд, алгоритмын давамгайлал нь зүгээр нэг технологийн асуудал бус, харин сэтгүүл зүй, олон нийтийн санаа бодол,

ардчиллын суурь нөхцөлд нөлөөлж буй бүтцийн чанартай өөрчлөлт юм. Энэхүү өөрчлөлтийг онолын хувьд ойлгож, бодлогын түвшинд зөв удирдан чиглүүлэх нь дижитал харилцааны системүүдийг мэдээлэлтэй, олон нийтийн ашиг сонирхолд нийцсэн, үзэл бодлын олон ургальч байдлыг дэмжсэн чиглэлд хадгалахад зайлшгүй шаардлагатай юм.

Эшлэл

- Ahmmad, M., Shahzad, K., Iqbal, A., & Latif, M. (2025). *Trap of social media algorithms: A systematic review of research on filter bubbles, echo chambers, and their impact on youth*. Societies, 15(11), 301. <https://www.mdpi.com/2075-4698/15/11/301>
- Areeb, Q. M., Nadeem, M., Sohail, S. S., et al. (2023). *Filter bubbles in recommender systems: Fact or fallacy—A systematic review*. Wiley Interdisciplinary Reviews: Data Mining and Knowledge Discovery. <https://doi.org/10.1002/widm.1512>
- Bauer, C., Bagchi, C., & Hundogan, O. A. (2024). *Where are the values? A systematic literature review on news recommender systems*. Proceedings of the ACM Conference on Recommender Systems. <https://doi.org/10.1145/3654805>
- Chalikiopoulou, E., Saridou, T., & Veglis, A. (2025). *The role of generative AI in enhancing audience participation in journalism: A scoping review*. Societies, 15(12), 358. <https://www.mdpi.com/2075-4698/15/12/358>
- Essien, E. O. (2025). *Climate change disinformation on social media: A meta-synthesis on epistemic welfare in the post-truth era*. Social Sciences, 14(5), 304. <https://www.mdpi.com/2076-0760/14/5/304>
- Foà, C., & Couraceiro, P. (2024). *Decoding algorithmic literacy among journalists*. Observatorio (OBS*) Journal.
- Hunt, R., & McKelvey, F. (2019). *Algorithmic regulation in media and cultural policy*. Journal of Information Policy, 9, 307–335. <https://doi.org/10.5325/jinfopoli.9.2019.0307>
- Leblanc, C., & Roux, A. (2025). *AI and social media: An integrative literature review*. <https://hal.science/hal-05041614>
- Møller, L. A. (2022). *Between personal and public interest: Algorithmic news recommendation*. Digital Journalism. <https://doi.org/10.1080/21670811.2022.2032782>
- Ogwoni, G. R., Ibiyeye, O. F., Adediji, M. N., & Ejeh, F. M. (2025). *Algorithmic curation and information visibility on social media*. Mass Media Review.
- Reviglio, U. (2020). *Personalization in social media: Challenges and opportunities for democratic societies*. University of Bologna.
- Tayie, S. S. (2025). *Fostering algorithmic literacy in education*. Comunicar.
- Ukkola, A. (2025). *The influence of social media recommendation algorithms on opinion polarization*. University of Jyväskylä.

Summary

This study examines the growing influence of algorithmic systems on public opinion formation in the digital media environment. As social media platforms increasingly rely on algorithms to curate, prioritize, and distribute information, these systems have become powerful actors in shaping public discourse, media consumption patterns, and collective perceptions. The research explores how algorithmic mediation affects information visibility, agenda-setting processes, echo chambers, and the polarization of audiences. Drawing on theories of digital communication, gatekeeping, and platformization, the study analyzes the ways in which algorithmic dominance transforms the relationship between media institutions, journalists, and audiences. The paper further discusses the implications of algorithm-driven communication for democratic participation, media ethics, and the credibility of journalism in Mongolia's evolving digital landscape. The findings suggest that while algorithms enhance the speed and personalization of information delivery, they also pose challenges related to misinformation, selective exposure, and the fragmentation of public opinion. Ultimately, the study highlights the need for greater algorithmic transparency, media literacy, and responsible digital communication practices in contemporary society.

Keywords: Algorithmic dominance; Public opinion; Algorithmic gatekeeping; Digital platforms; Social media algorithms; Public opinion formation; Personalization; Filter bubbles; Echo chambers; Misinformation; Media legitimacy and public trust; Platformization; Digital journalism; Algorithmic curation; Opinion polarization.